



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 16 өдөр

Дугаар А/246

Сүхбаатар сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", 29.1.6 "г", 29.2, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3 Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.6 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 113 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсад хамгийн олон жилийн баялаг түүхтэй, Монголчууд эрх чөлөө тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэн босож анхны ялалтаа эргэлт буцалтгүй хийсэн, Ардын хувьсгалын анхны ялалтын түүхэн нутаг Алтанбулаг сум байгуулагдсаны 290 жилийн ой тохиож буйтай холбосгдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг даргын мэндчилгээ бүхий 100000 /Зуун мянган/ төгрөгийн дурсгалын зүйлс бэлтгэн, 3000000 /Гурван сая/ төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Зардалд шаардагдах нийт 3100000 /Гурван сая нэг зуун мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Мөнхбаяр/-т зөвшөөрсүгэй.

3. Зардлын тайланг 2019 оны 8 дугаар сарын 1-ний дотор гаргаж тайлагнахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга /Д.Лувсандагва/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ